

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР

2020 ОНЫ ХОЁРДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 02 дугаар сарын 29

Дорнод аймаг

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, А/75 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд ОХУ-ын гарцтай Ульхан, Эрээнцав, боомтууд хэлэлцээр ёсоор хуваарийн дагуу ажиллалаа. БНХАУ-ын гарцтай авто замын Баянхошуу, Бичигт боомтууд хөдөлгөөний хязгаарлалттай ажиллаж, Хавирга боомт Засгийн газрын 2020 оны 39 дугаар тогтоолын дагуу түр хаасан. Тус хугацаанд 1 албан хаагч ажлын 5 хүртэлх хоногийн чөлөө авсан, 1-н албан хаагч удаан хугацааны эмчилгээний магадлагаатай байлаа.

Нэг. Захиргаа, удирдлага

Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст Бүсийн газрын 02 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, 2 дугаар сарын төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, 03 дугаар сард хийх ажлын төлөвлөгөө тус тус хүргүүлсэн.

2020 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 26-ны өдрүүдэд сар шинийн баяр болохтой холбоотойгоор амралтын олон хоногууд тохиож байсан тул тус өдрүүдэд аюулгүй байдлыг хангах үүднээс хариуцлагатай жижүүрийн хуваарь баталж ажилласан. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж дууссан.

Уулзалт, зөвлөгөөн, хамтын ажиллагаа. Даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд дарга, ахлах мэргэжилтэн нар сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатын баталсан “Хилийн боомтод ажиллах” удирдамжийн дагуу 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ны өдрүүдэд Гадаадын иргэн, харьяатын Зүүн бүс дэх газар, БОЭТ, Дорнод аймгийн Тагнуулын газар, Мэргэжлийн хяналтын газар, Дорнод аймгийн Гаалийн газар, хилийн 0275 дугаар анги зэрэг нийт 7 байгууллага Ульхан, Эрээнцав боомтоор нэвтэрч байгаа зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавих, тандалт үзлэг хийх, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг хамтран хийж гүйцэтгэсэн.

Сургалтад хамрагдсан талаар: Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Бүсийн газраас зохион байгуулсан сургалт болон бусад сургалтанд хамрагдсан албан хаагч байхгүй.

Бичиг хэргийн эргэлтийн талаар: Ирсэн бичиг: Байгууллагын удирдлагаас 8, бусад байгууллагаас нийт 7, нийт 15-н албан бичиг ирж, үүнээс хариутай 1 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.

Явсан бичиг: Ажлын зохион байгуулалттай холбоотойгоор байгууллагын удирдах албан тушаалтанд явуулсан албан бичиг 1, бусад байгууллагад 7 албан бичиг үйлдэж холбогдох байгууллагуудад явуулж мэдээ мэдээлэл солилцон ажилласан байна.

Өргөдөл: Тус сард албан хаагчдаас хувийн чөлөө хүссэн 1, Бүсийн төвд түр ажиллах 1 өргөдөл хүсэлт хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн.

Санхүүгийн талаар: 2020 оны 02 дугаар сард 57,426,400.00 төгрөгийн санхүүжилтийг авснаас 37,480,714.99 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.

2020 оны 01 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 69,744,600.00 төгрөгийн санхүүжилт, 36,730,564.64 төгрөгийн гүйцэтгэлтэй, 33,014,035.36 төгрөгийн үлдэгдэлтэй гарсаныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 01 дүгээр сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 13,613,000.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 560,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цалин хөлсний нийгмийн даатгалын 01 дүгээр сарын тайлангаар нь нийт 27 албан хаагчдын 28,043,801.35 цалин, ногдол 6,416,334.37 төгрөг гарсаныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж шинэчлэгдсэн сайтанд 2020 оны 01 дүгээр сарын мэдээллийг хуулийн хугацаанд шивж дуусгасан.

Сар бүр санхүүгийн ил тод байдлын самбарын мэдээллийг шинэчлэн албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр ханган ажиллаж байна.

2019 оны 02 дугаар сарын 12-ноос 2019 оны 022 дугаар сарын 14-ний хооронд 2019 оны санхүүгийн тайлангийн аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ОСНББОУС, түүнд нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн зөрчилгүй гарсан.

Жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг Гадаадын иргэн, харьяатын газрын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Эд, хөрөнгө, хангалтын талаар: Бараа материалын тайланг сарын 29-ны өдрөөр тасалбар болгон Нийтийн аж ахуй, “ДБЭХС”, “Цахилгаан холбоо”, “Монгол шуудан”, “Мэдээлэл холбоо”, “НИК”, ХХК -тай тулгалтыг хийж тооцоо нийлсэн акт үйлдэн ажиллаа. Мөн Бүсийн газрын автомашины зам/км, шатахуун, бараа материалын тооцоог гаргаж ахлах нягтлан бодогчид тайлагнасан.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтын 29-д Ульхан, Эрээнцав, Хавирга, Баянхошуу боомтуудад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах төлөвлөгөөний дагуу усны сав 6 ширхэг, ус цэвэршүүлэгч 1 ширхэг зэргийг 405,400 төгрөгөнд худалдан аваад байна.

“Корона” вирус болон ханиад өвчинөөс урьдчилан сэргийлэхийн тулд албан хаагч нартаа анхан шатны тусламжийн эм, тариур, аптек зэргийг 325,860 төгрөгөнд худалдан авч боомтод хүргүүлсэн.

Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт, шаардах хуудасны дагуу хувин хэргийн дэвтэр хоёр ширхэг, бланк двд 50 ширхэг, 54,440 төгрөг, бүсийн төв болон боомтуудад ариутгалын бодис 8 ширхэг буюу 19600 төгрөгөнд бараа материалыг худалдан авч холбогдох албан тушаалтан нарт шаардах хуудасны дагуу олгосон.

Хангалт үйлчилгээний чиглэлээр: Албаны 65-99 ДОР улсын дугаартай “Тоёота приус” автомашины аюулгүй байдлыг хангах үүднээс таван булын резин, товуд, комут арын түлк резин, хэвтээ тэнцүүлэгчийн түлк зэргийг 193,200 төгрөгөнд худалдан авч стандарт нормын дагуу сольж техник үйлчилгээг хийлгэсэн.

Мэдээлэл, технологийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж ажилласан. Бичигт боомтын дотоод сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Б.Ганзориг, хяналтын улсын байцаагч Г.Хосбаатар, мэргэжилтэн А.Нэмэхбаяр нарын “ISM” системийн шилжүүлэх эрхийг бүртгэн авч, хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн.

Хилийн боомтуудын дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа 9 ширхэг компьютерт Eset endpoint security антивирусны програмын лицензийг сунгаж 02 дугаар сарын антивирусны програмын шинэчлэлтийг хийж ажилласан.

Бүсийн газрын интернэт сүлжээний түрээсийн талаар дарга Б.Тамир, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга Л.Батсүх нарт илтгэх хуудсаар танилцуулсан.

“Эс Ай Си Ти” ХХК болон Дорнод аймгийн “Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨК-тай хамтран интернэт сувгийн түрээсийг шинэчлэх зорилгоор интернэтийн шилэн кабелийг амжилттай тестлэж сүлжээг шинэчлэхэд бэлэн болгосон.

Хил хамгаалах ерөнхий газрын 275-р анги дотоод сүлжээнд өргөтгөл хийсэнтэй холбоотой бүсийн газрын Эрээнцав боомт нь 02 дугаар сарын 03-ны өдрөөс Чулуунхороот сумаас чиглэлтэй антенаар “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-аас дотоод сүлжээг ашигладаг болсон. Үүнтэй холбоотойгоор Эрээнцав боомтод ашигладаг байсан 71000630 дугаартай ВСАТ-ын утас ашиглах боломжгүй болсон бөгөөд Хавирга боомтод шилжүүлэх шаардлагатай талаар дарга Б.Тамир, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга Л.Батсүх нарт илтгэх хуудсаар танилцуулсан.

Төрийн албаны ил тод, нээлттэй байх, иргэдийг мэдээллээр хангах эрхийн дагуу www.immigration.gov.mn сайтын “Боомт орон нутаг” цэсэд 01 дүгээр сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 02 дугаар сарын төлөвлөгөөг шинэчлэн оруулсан.

Хилийн боомтуудын хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” систем болон компьютер техникийн 2 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.

Хоёр. Виз, зөвшөөрлийн чиглэлээр

Хариуцсан хилийн боомтуудаар нийт 2 орны, гадаадын 134 /БНХАУ, ОХУ/ иргэн улсын хилээр нэвтэрснээс орох чиглэлд 68, гарах чиглэлд 66 гадаадын иргэн нэвтэрсэн байна.

Виз олголт: Тайлант хугацаанд виз олгогдоогүй.

Виз сунгалт: Байхгүй.

Алдаатай визийн бүртгэл: байхгүй

Түр ирэгчийн бүртгэл -5, хасалт-1

Бүсийн төвд: Дорнод их Сургуулийн албан хүсэлтээр “S” ангиллын визтэй БНХАУ-ын 4 иргэн, хувь хүний хүсэлтээр “B” ангиллын нэг удаагийн “орох” зориулалтын визийн сунгалт 1 нийт 5 иргэнийг түр ирэгчийн бүртгэлд бүртгэж, “B” ангиллын нэг удаагийн “орох” зориулалтын визийн сунгалт хийсэн 1 иргэнийг түр ирэгчээс тус тус хасалт хийсэн байна.

Оршин суух зөвшөөрлийн хасалт: Бүсийн төвд “Шинэ интернэшнл” ХХК-ны албан хүсэлтээр БНХАУ-ын хөдөлмөр эрхлэх ОСЗ-тэй 1 иргэн хасалт хийж мөн БНХАУ-ын хөдөлмөр эрхлэх ОСЗ-тэй 1 иргэнд нөхөж оршин суух зөвшөөрөлд хасалт хийсэн.

ХОНДЗҮ-ээр хил нэвтэрсэн гадаадын иргэн байхгүй.

Хурууны хээ: Байхгүй.

Хувийн урилга: Тайлант хугацаанд хувийн урилга олгоогүй.

Зөвөлгөө мэдээлэл: 20 иргэнд зөвөлгөө мэдээлэл өгсөн. Үүнээс:

- Хавирга боомтод: БНХАУ-ын 7 иргэнд виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- Бичигт боомтод: БНХАУ-ын 3 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар;

- Бүсийн төвд 10 иргэн, аж ахуйн нэгжид виз, визийн ангилал, түр ирэгчийн талаар зөвлөгөө өгсөн.

Ярилцлага хийсэн бүртгэл: 2

- Хилийн боомтуудад ОХУ-ын 2 иргэний виз Монгол Улсад зорчих зорилготой нийцсэн эсэх талаар ярилцлага хийн тэмдэглэл хөтөлсөн. Үүнд: Ульхан боомтод 2 иргэнтэй тус ярилцлага хийсэн.

Сүлжээний хяналт: ОХУ-д гарцтай Ульхан, Эрэнцав, БНХАУ-д гарцтай авто замын Баянхошуу, Бичигт боомтуудад хилээр зорчсон 2 орны 134 иргэний хөдөлгөөнд хяналт тавьж, 10 гадаадын иргэний мэдээллийг “ISM” сүлжээнд шалган нэвтрүүлсэн.

Гурав. Хяналт шалгалтын чиглэлээр

Тус газар нь хоёрдугаар сарын тайлангийн хугацаанд Бүсийн газрын даргын баталсан №12/05-2020/03, Бүсийн дарга, Дорнод аймаг дахь Тагнуулын газрын

даргын хамтарсан №12/05-2020/04 тоот удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 2 , нийт 4 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтанд нийт 28 аж ахуй, нэгжийн гадаадын 98 /БНХАУ-ын 90, Иран улсын 1, БНСВУ-ын 2, БНСУ-ын 5 / иргэн хамрагдаж, БНХАУ-ын 2 иргэнтэй Монгол Улсад ирсэн зорилгыг тодорхойлохоор ярилцлага хийж, шалгалтанд хамрагдсан аж ахуй нэгжийн удирдлага болон гадаадын 30 иргэнд зөвөлгөө өгч ажилласан. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд 2 аж ахуй нэгжийн гадаадын 12 иргэн / БНСУ-ын 10, БНХАУ-ын 2/ хамрагдаж, 12 иргэнд зөвөлгөө өгсөн, шалгалтаар илэрсэн зөрчилгүй.

Тайлангийн хугацаанд зөрчил шийдвэрлэгдээгүй.

Дэлхийн хэмжээнд дэгдээд буй корона вирусын дэгдэлтэй холбоотойгоор авч буй арга хэмжээний хүрээнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, гадаадаас ажиллах хүч урьж хамтран ажиллаж байгаа байгууллагуудад хилийн боомтоор нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийг хязгаарласантай холбогдуулж, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар “МЭДЭГДЭЛ” хүргүүлсэн.

Хил дээрээс буцаагдсан иргэдийн талаар: Байхгүй.

Албадан гаргалтын талаар: Байхгүй.

Албан шаардлага хүргүүлж ажилласан талаар: Албан шаардлага хүргүүлсэн аж ахуй нэгж байхгүй.

Байгууллагын даргын №04 албан даалгаврын хүрээнд:

Хяналт, шинжилгээ дотоод аудит, орон нутгийн хэлтсээс 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 09/305 тоот албан бичгээр ирүүлсэн Бүсийн хэмжээнд албан болон хувийн хэргээр оршин оршин сууж буй иргэдийн оршин суух зөвшөөрөлд хяналт тавьж хасалт хийгдээгүй хилээр гарсан 12 иргэнд хасалтыг нөхөж хийсэн.

ТАНИЛЦСАН.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ДОТООД АУДИТ, ОРОН
НУТГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАТСҮХ

ХЯНАСАН.

ХЯНАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Б.ЭРДЭНЭТУЯА

ТАЙЛАН БИЧСЭН.
МЭРГЭЖИЛТЭН

А.НЭМЭХБАЯР